



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 4/02

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах мэргэжлийн
бүлэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.2.4 дэх заалт, Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/379 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Нийгмийн хамгааллын тусгай төвийн хэвийн үйл ажиллагааг хангах, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий гамшгаас хамгаалах мэргэжлийн бүлгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хувцас, багаж хэрэгслийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, мэргэжлийн ангид хөтлөгдөх баримт бичгүүдийг тухай бүр шинэчилж байхыг ХАБЭА-н ажилтан эмч (Б.Гэрэлмаа)-д даалгасугай.

3. Гамшгаас хамгаалах хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь заалтад заасны дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлыг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, мэргэжлийн бүлэгт шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэж, ажиллах нөхцөлөөр хангахыг Нягтлан бодогч (Б.Энхдолгор)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.МӨНХЦЭЦЭГ

1825010015


Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2025 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн
1/02 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Албан тушаал		Овог нэр
	Томилгоожсон	Үндсэн	
1	Штабын дарга	Дарга	Ш.Мөнхцэцэг
2	Холбоо мэдээлэл хариуцсан туслах	Ахлах арга зүйч	М.Мөнхсайхан
3	Сургалт, мэргэжлийн ангийн бэлэн байдал хариуцсан туслах	Ахлах нийгмийн ажилтан	Б.Нандинцэцэг
5	Хамгаалах арга хэмжээ хариуцсан туслах	Нийгмийн ажилтан	Н.Нэргүй
6	Мэргэжлийн хангалт хариуцсан туслах	Ерөнхий нягтлан бодогч	Б.Энхдолгор
7	Олон улсын хөл хорио болон хурц халдварт өвчний ажлын хэсгийн ахлагч	Эмч	П.Рагчаабазар
8	Эмнэлгийн албаны тогтвортой ажиллагаа хариуцсан туслах	Нийгмийн ажилтан	О.Насанбуян
9	Эмнэлгийн анхны тусламж хариуцсан туслах	Нийгмийн ажилтан	Б.Чинбат
10	Оператор	Архив бичиг хэргийн ажилтан	Г.Мөнгөнзул

Нийгмийн хамгааллын тусгай төвийн даргын
2025 оны 01 дугаар сарын 14-ны өдрийн
4/01 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн ажлын хувцас,
багаж хэрэгслийн жагсаалт

Д/д	Ажлын хувцас, багаж хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Нүдний хамгаалах хэрэгсэл	ширхэг	30
2	Малгай, каск	Ширхэг	100
3	Ажлын хувцас /өвөл, зуны/	Хос	5
4	Ажлын гутал	хос	5
5	Бээлий	хос	100
6	Цув	ширхэг	7
7	Гар чийдэн	ширхэг	1
8	Мяндсан олс	метр	100
9	Бэхэлгээний бүс	ширхэг	1
10	Хүрз	ширхэг	7
11	4 хүний майхан	ширхэг	1
12	Аяны хөнжил	ширхэг	1
13	Эмийн сан, анхны тусламжийн иж бүрдэл	хайрцаг	2
14	Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл	ширхэг	1
15	Дамнуурга	ширхэг	1